# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/158/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох<br>Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**...3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**...5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан...5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан...6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан...7-8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн ...8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан...9-10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан...11
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА...11**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа...11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин...12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал...12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд...12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв...13
3.5.1 Төсвийн төлөвлөлт...13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл...13
3.5.3 Нэмэлт төсөв...13
**4. АУДИТЫН ТАЙЛАН...14**
4.1 Ерөнхий зүйл...14
4.2 Материаллаг байдал...14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт...14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал...14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт...15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд...15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт...15
4.5.1 Завсрын аудитын талаар...16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн...17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал...17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ...17**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,
Утас/факс: 7045-3317,
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.01.27 № УВА-2026/158/НА-СТА-ТШЗ
танай_____________-ны №________________-т

ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050042

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,873,834.00** | **36,839,127.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 5,000,000.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 5,000,000.00 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | 5,000,000.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 5,000,000.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 2,000,000.00 | 5,450,493.00 |
| **335** | **Бусад авлага** | 2,000,000.00 | 5,450,493.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,000,000.00 | 5,450,493.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33,873,834.00 | 31,388,634.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 33,873,834.00 | 31,388,634.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 12,431,000.00 | 8,932,580.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,292,934.00 | 22,306,154.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 149,900.00 | 149,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **943,364,482.54** | **986,899,020.63** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 943,364,482.54 | 986,899,020.63 |
| **392** | **Биет хөрөнгө** | 900,926,609.54 | 944,667,397.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 628,309,270.00 | 628,309,270.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -95,316,937.33 | -111,488,588.29 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 82,000,000.00 | 82,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -21,183,333.47 | -37,383,333.47 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 253,830,529.68 | 297,273,605.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -67,327,160.11 | -94,186,364.60 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 135,209,500.00 | 212,467,611.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -17,164,554.23 | -34,874,097.84 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -860,000.00 | -980,000.00 |
| 39217 | Ном | 2,229,295.00 | 2,329,295.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 42,437,873.00 | 42,231,623.00 |
| 39301 | Програм хангамж | 825,000.00 | 825,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -515,625.00 | -721,875.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **984,238,316.54** | **1,023,738,147.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,000,000.00** | **12,880,011.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,000,000.00 | 12,880,011.00 |
| **413** | **Өглөг** | 5,000,000.00 | 12,880,011.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 41,022.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 5,000,000.00 | 12,838,989.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00.00 | 6,498,250.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 5,000,000.00 | 6,340,739.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **979,238,316.54** | **1,010,858,136.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 979,238,316.54 | 1,010,858,136.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 610,411,472.11 | 610,411,472.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 610,411,472.11 | 610,411,472.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 194,051,385.04 | 225,671,205.13 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 194,051,385.04 | 194,051,385.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 31,619,820.09 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 174,775,459.39 | 174,775,459.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **984,238,316.54** | **1,023,738,147.63** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,759,508,041.55** | **3,127,545,307.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **119,206,193.68** | **134,467,407.15** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 119,206,193.68 | 134,467,407.15 |
| 120009 | Бусад орлого | 34,613,000.00 | 9,210,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/үндсэн хөрөнгө | 81,681,793.68 | 125,257,407.15 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/бараа материал | 2,911,400.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,640,301,847.87** | **2,993,077,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,590,867,313.00 | 2,925,346,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,590,867,313.00 | 2,925,346,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,434,534.87 | 67,731,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,434,534.87 | 67,581,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 150,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,642,821,273.90** | **3,088,841,251.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,642,821,273.90** | **3,088,841,251.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,313,857,629.81 | 3,006,281,860.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,741,183,420.15 | 2,332,265,291.89 |
| 210101 | Үндсэн цалин | 1,044,880,124.35 | 1,504,541,251.87 |
| 210102 | Нэмэгдэл | 488,024,068.10 | 538,081,440.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 118,413,722.70 | 126,275,000.00 |
| 210104 | Урамшуулал | 89,865,505.00 | 163,367,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 216,267,496.71 | 288,037,584.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 149,205,796.67 | 198,482,981.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,553,623.66 | 23,407,967.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,715,996.00 | 11,654,481.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,122,963.23 | 10,898,446.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,669,117.15 | 43,593,708.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 87,013,105.64 | 123,884,285.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,276,360.04 | 9,479,583.55 |
| 210302 | Түлш, халаалт | 73,143,021.60 | 106,876,457.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,593,724.00 | 7,528,244.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 95,009,834.28 | 112,936,417.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 45,775,250.00 | 52,353,630.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,510,800.00 | 22,785,090.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,556,144.28 | 25,599,597.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 948,180.00 | 270,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,219,460.00 | 11,928,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 267,200.00 | 74,680.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 267,200.00 | 74,680.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 60,427,490.00 | 13,689,890.00 |
| 210604 | Урсгал засвар | 60,427,490.00 | 13,689,890.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 18,300,700.00 | 30,089,564.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,300,700.00 | 30,089,564.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,377,657.00 | 8,643,214.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,560,165.00 | 3,845,130.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,770,000.00 | 2,791,110.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 91,228.00 | 107,142.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |

20 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,792,000.00 | 737,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 400,264.00 | 398,832.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 75,010,726.03 | 96,660,933.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,768,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 75,010,726.03 | 94,892,433.83 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 328,963,644.09 | 82,559,391.40 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 181,739,013.00 | 16,489,800.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 543,600.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 108,000,000.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 62,329,413.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,866,000.00 | 16,489,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 142,295,631.09 | 64,512,344.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 142,295,631.09 | 64,512,344.78 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,929,000.00 | 1,557,246.62 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт/төвлөрүүлэх шилжүүлэг | 4,929,000.00 | 1,557,246.62 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **116,686,767.65** | **38,704,055.32** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 7,084,235.23 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал/үндсэн хөрөнгө | 00.00 | 2,094,335.23 |
| 225006 | Үнэ төлбөргүй гарсан зардал/бараа материал | 00.00 | 4,989,900.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -7,084,235.23 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **116,686,767.65** | **31,619,820.09** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,647,153,847.87** | **2,993,262,728.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,000,000.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 5,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,642,153,847.87** | **2,993,262,728.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,590,867,313.00 | 2,925,346,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,590,867,313.00 | 2,925,346,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 51,286,534.87 | 67,916,628.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,434,534.87 | 67,581,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,852,000.00 | 334,828.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,572,683,347.87** | **2,992,208,828.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,572,683,347.87** | **2,992,208,828.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,243,719,703.78** | **2,909,669,436.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,741,183,420.15 | 2,332,265,291.89 |
| 210101 | Үндсэн цалин | 1,044,880,124.35 | 1,504,541,251.87 |
| 210102 | Нэмэгдэл | 488,024,068.10 | 538,081,440.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 118,413,722.70 | 126,275,000.00 |
| 210104 | Урамшуулал | 89,865,505.00 | 163,367,600.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 216,267,496.71 | 288,037,584.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 149,205,796.67 | 198,482,981.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,553,623.66 | 23,407,967.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,715,996.00 | 11,654,481.60 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,122,963.23 | 10,898,446.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,669,117.15 | 43,593,708.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 87,013,105.64 | 123,884,285.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,276,360.04 | 9,479,583.55 |
| 210302 | Түлш, халаалт | 73,143,021.60 | 106,876,457.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,593,724.00 | 7,528,244.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 97,982,334.28 | 105,386,637.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 49,181,750.00 | 41,049,310.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,510,800.00 | 23,761,090.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,556,144.28 | 25,599,597.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 948,180.00 | 270,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,785,460.00 | 14,206,640.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 255,000.00 | 298,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 255,000.00 | 298,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 60,947,990.00 | 17,358,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,989,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 60,947,990.00 | 12,368,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 18,300,700.00 | 24,676,164.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,300,700.00 | 24,676,164.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,769,657.00 | 15,994,174.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,952,165.00 | 11,196,090.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,770,000.00 | 2,791,110.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 91,228.00 | 107,142.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,792,000.00 | 737,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 400,264.00 | 398,832.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 1,768,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,768,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **328,963,644.09** | **82,539,391.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 181,739,013.00 | 16,469,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 108,000,000.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 62,329,413.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,409,600.00 | 16,469,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 142,295,631.09 | 64,512,344.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 142,295,631.09 | 64,512,344.78 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,929,000.00 | 1,557,246.62 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт/төвлөрүүлэх шилжүүлэг | 4,929,000.00 | 1,557,246.62 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **74,470,500.00** | **1,053,900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **76,970,500.00** | **6,053,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **76,970,500.00** | **6,053,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 76,970,500.00 | 6,053,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 76,970,500.00 | 6,053,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-76,970,500.00** | **-6,053,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -2,500,000.00 | -5,000,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 7,500,000.00 | 5,000,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5,000,000.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 610,411,472.11 | 174,775,459.39 | 77,364,617.39 | 862,551,548.89 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **77,364,617.39** | **862,551,548.89** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 116,686,767.65 | 116,686,767.65 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **194,051,385.04** | **979,238,316.54** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **194,051,385.04** | **979,238,316.54** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **194,051,385.04** | **979,238,316.54** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 31,619,820.09 | 31,619,820.09 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **610,411,472.11** | **174,775,459.39** | **225,671,205.13** | 1,010,858,136.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,000,592,500.00 | 2,860,833,755.22 | 139,758,744.78 | 95.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,000,592,500.00 | 2,860,833,755.22 | 139,758,744.78 | 95.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,978,562,500.00 | 2,844,363,955.22 | 134,198,544.78 | 95.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,339,327,400.00 | 2,274,963,808.98 | 64,363,591.02 | 97.2 |
| 210101 | Үндсэн цалин | 1,387,987,000.00 | 1,504,541,251.87 | -116,554,251.87 | 108.4 |
| 210102 | Нэмэгдэл | 587,571,700.00 | 480,779,957.11 | 106,791,742.89 | 81.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 166,125,600.00 | 126,275,000.00 | 39,850,600.00 | 76.0 |
| 210104 | Урамшуулал | 197,643,100.00 | 163,367,600.00 | 34,275,500.00 | 82.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 292,415,800.00 | 280,979,686.09 | 11,436,113.91 | 96.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 198,842,800.00 | 193,612,355.44 | 5,230,444.56 | 97.4 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧЛӨЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,393,300.00 | 22,834,952.38 | 558,347.62 | 97.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,696,600.00 | 11,367,976.18 | 328,623.82 | 97.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,696,600.00 | 10,632,880.41 | 1,063,719.59 | 90.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 46,786,500.00 | 42,531,521.68 | 4,254,978.32 | 90.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 131,616,700.00 | 123,884,285.15 | 7,732,414.85 | 94.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,316,700.00 | 9,479,583.55 | 2,837,116.45 | 77.0 |
| 210302 | Түлш, халаалт | 109,932,500.00 | 106,876,457.60 | 3,056,042.40 | 97.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,367,500.00 | 7,528,244.00 | 1,839,256.00 | 80.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 109,053,400.00 | 105,486,637.00 | 3,566,763.00 | 96.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 41,621,100.00 | 41,049,310.00 | 571,790.00 | 98.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,942,100.00 | 23,761,090.00 | 4,181,010.00 | 85.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 26,125,400.00 | 25,599,597.00 | 525,803.00 | 98.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 600,000.00 | -500,000.00 | 600.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 883,100.00 | 270,000.00 | 613,100.00 | 30.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,381,700.00 | 14,206,640.00 | -1,824,940.00 | 114.7 |
| **2105** | **Нормативт зардал** | 995,100.00 | 298,000.00 | 697,100.00 | 29.9 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 995,100.00 | 298,000.00 | 697,100.00 | 29.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,165,300.00 | 21,312,700.00 | 32,852,600.00 | 39.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,399,800.00 | 8,943,800.00 | 2,456,000.00 | 78.5 |
| 210602 | Тавилга | 20,000,000.00 | 00.00 | 20,000,000.00 | 0.0 |
| 210604 | Урсгал засвар | 22,765,500.00 | 12,368,900.00 | 10,396,600.00 | 54.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 32,453,800.00 | 24,676,164.00 | 7,777,636.00 | 76.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 32,453,800.00 | 24,676,164.00 | 7,777,636.00 | 76.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,393,000.00 | 10,994,174.00 | 5,398,826.00 | 67.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,722,400.00 | 6,196,090.00 | 4,526,310.00 | 57.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,799,900.00 | 2,791,110.00 | 8,790.00 | 99.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 107,200.00 | 107,142.00 | 58.00 | 99.9 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 44,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,500,000.00 | 737,000.00 | 763,000.00 | 49.1 |
| 210807 | Газрын төлбөр | 499,500.00 | 398,832.00 | 100,668.00 | 79.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2142000.00 | 1768500.00 | 373,500.00 | 82.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,142,000.00 | 1,768,500.00 | 373,500.00 | 82.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22030000.00 | 16469800.00 | 5,560,200.00 | 74.8 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,030,000.00 | 16,469,800.00 | 5,560,200.00 | 74.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 22,030,000.00 | 16,469,800.00 | 5,560,200.00 | 74.8 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,000,592,500.00 | 2,925,346,100.00 | 75,246,400.00 | 97.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,000,592,500.00 | 2,925,346,100.00 | 75,246,400.00 | 97.5 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,000,592,500.00 | 2,925,346,100.00 | 75,246,400.00 | 97.5 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 05.00 | 05.00 | 0.00 | |
| 610001 | Төсвийн байгууллага | 05.00 | 05.00 | 0.00 | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 62 | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37.00 | 37.00 | 0.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28.00 | 28.00 | 0.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | |
| 620004 | Удирдах ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **66,359,381.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **66,359,381.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 66,359,381.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 57,301,482.91 |
| 210102 | Нэмэгдэл | | 57,301,482.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 7,057,898.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 4,870,626.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 573,014.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 286,505.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 265,565.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 1,062,186.48 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 2,000,000.00 |
| 210602 | Тавилга | | 2,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 67916628.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 67,916,628.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 67,581,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 334,828.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр Шүүхийн захиргааны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах;
- Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах;
- Шүүхийн хүний нөөцийг удирдах;
- Шүүхийн төсөв, санхүү, дэд бүтцийг удирдах;
- Шүүхийн нээлттэй байдлыг хангах, олон нийттэй харилцах зэрэг болно.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, иргэний эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Төсвийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд, Нийгмийн даатгал болон татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 274 дүгээр тогтоолын хавсралтаар "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ";
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 209 дүгээр тогтоол "Анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээ"

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн шууд захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 215 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,499.8 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 5,000.0 | 0.0 | -5,000.0 |
| Авлага | 2,000.0 | 5,450.5 | 3,450.5 |
| Бараа материал | 33,873.8 | 31,388.6 | -2,485.2 |
| Үндсэн хөрөнгө | 943,364.5 | 986,899.0 | 43,534.5 |
| **Нийт хөрөнгө** | **984,238.3** | **1,023,738.1** | **39,499.8** |
| Өр төлбөр | 5,000.0 | 12,880.0 | 7,880.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 979,238.3 | 1,010,858.1 | 31,619.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **984,238.3** | **1,023,738.1** | **39,499.8** |

Авлагын данс үлдэгдэл 5,450.5 мянган төгрөг болж 3,450.6 мянган төгрөгөөр өссөн нь шүүгчийн захирамжаар гэр бүлийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой үүссэн нөхцөл байдлын үнэлгээ хийлгэсэн 8 иргэдээс авах авлага нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31,388.6 мянган төгрөг болж 2,485.2 мянган төгрөгөөр буурсан нь 1,000.0 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассантай голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 986,899.0 мянган төгрөг болж 43,534.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,053.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, шүүхийн ерөнхий зөвлөлөөс 125,257.4 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,880.0 мянган төгрөг болж өссөн нь батлагдсан төсөв хуваарийн дагуу олгогдоогүйн улмаас шүүн таслах ажиллагааг тасралтгүй явуулах үүднээс бичиг хэрэг, томилолтын зардлын өр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,010,858.1 мянган төгрөг болж 31,619.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,925,855.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 925,263.3 мянган төгрөгөөр бууруулж 3,000,592.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 арга хэмжээг улсын төсвөөс 2,925,346.1 мянга, орон нутгийн төсвөөс 67,581.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 334.8 мянга, нийт 2,993,262.7 мянган төгрөгийн санхүүжилтээс бүрдсэн байна.

ҮВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,860,833.8 мянган төгрөг буюу 95.3 хувьтай буюу улсын төсөвт 64,512.3 мянга, орон нутгийн төсөвт 1,557.2 мянган төгрөгийн тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал 70701,80101 | 2,967,840.1 | 2,838,167.9 | 129,672.2 | 95.6 |
| 2 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд 70701,80224 | 1,810.4 | 1,624.7 | 185.7 | 89.7 |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж 70701,80802 | 22,030.0 | 16,469.8 | 5,560.2 | 74.7 |
| 4 | Шинжээч орчуулагч, хэлмэрчийн зардал 70701,82321 | 6,248.0 | 2,907.3 | 3,340.7 | 46.5 |
| 5 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх 70701, 81569 | 2,664.0 | 1,664.0 | 1,000.0 | 62.5 |

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 67,581.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 334.8 мянга нийт 67,916.6 мянган төгрөгийн орлого бүрджээ.

Төрийн захиргааны албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл 64,359.4 мянга, ус цэвэршүүлэгч 2,000.0 мянга, нийт 66,359.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,557.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газар 2025 онд харьцуулалтын аргаар тендер зарлаж шатах тослох материалын зардалд 23,761.0 мянган төгрөг, цахим дэлгүүрээс 1,519.0 мянган төгрөгийн хөрөнгийг ерөнхий гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 2,642,821.2 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 26,428.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 21,142.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,088,541.2 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 30,885.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 24,708.3 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**Аудитын ерөнхий судалгааны дүн**

/мянган төгрөг/

| | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Программ хангамжийн бүртгэл | 825.0 | Нягтлан бодох бүртгэлийн 550.0 мянга, нярвын тайлан гаргах 275.0 мянган төгрөгийн 2 программ байна. |
| 2 | Унаа, хоолны зарцуулалт | 126,275.0 | 2025 онд 166,125.6 мянган төгрөг батлагдаж 126,275.0 мянган төгрөг зарцуулж 39,850.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна. |
| 3 | Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал | 0 | Зардал гараагүй |
| 4 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0 | Зардал гараагүй |
| 5 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0 | Зардал гараагүй |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Орон тоо | 0 | 2025 онд 43 орон батлагдаж удирдах 5, гүйцэтгэх 22, үйлчилгээний 10 нийт 37 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна. |

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 169, хугацаа хоцроосон 0, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж өгөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 3. 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

9065585 1525010041

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР /Ч.МӨНХТОГТОХ/

2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ